



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/281

Улаанбаатар хот

### Нийслэлийн ерөнхий боловсролын 142 дугаар сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхээс болон Дезерет олон улсын байгууллагаас хандивласан 4,440,000.0 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 142 дугаар сургууль (Ч.Наранцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 142 дугаар сургууль (Ч.Наранцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *А. Оюунмаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
 даргын 2025 оны 03 дүгээр сарын 02-ны  
 өдрийн 128 дугаар тушаалын хавсралт

БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: 142-р сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Принтер /erson/	Epson-L4263	3 үйлдэлт	2024	сайн	ш	1	840,000.00	840,000.00	Эцэг эх	хандив
	Машин тоног төхөөрөмжийн дүн						1	840,000.00	840,000.00		
2	Суудравч	монгол	мөд, төмөр	2024	сайн	м.кв	1	3,600,000.0	3,600,000.0		
	Тавилга, эд хогшлын дүн						1	3,600,000.0	3,600,000.0		
	Нийт бүртгэх хөрөнгийн дүн						2	4,440,000.0	4,440,000.0		